

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/029/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Амармэнд Утас: 70453799, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
33	АВЛАГА	52,807.31	350,547.73
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	52,807.31	300,547.73
335	Бусад авлага	0.00	50,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	50,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	167,095,816.10	235,259,046.10
354	Хангамжийн материал	134,310,483.10	202,473,713.10
3541	Бичиг хэргийн материал	254,100.00	254,100.00
3542	Аж ахуйн материал	83,962,383.10	132,127,613.10
3543	Сэлбэг хэрэгсэл	22,816,000.00	22,816,000.00
3546	Хүнсний материал	278,000.00	0.00
3547	Бусад хангамжийн материал	27,000,000.00	21,348,000.00
356	Мал амьтад	32,785,333.00	32,785,333.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	167,148,623.41	209,681,593.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,337,260,206.13	4,606,630,092.91
392	Биет хөрөнгө	4,199,394,006.13	4,466,063,892.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,724,652,469.40	3,064,233,554.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-446,792,953.21	-538,916,536.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	422,069,546.00	469,569,546.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-131,092,209.55	-183,129,330.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	201,493,668.00	209,993,668.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-112,302,685.33	-142,449,373.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,913,627.61	164,213,627.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,608,202.00	-69,869,018.27
39209	Зам, гүүрийн байгууламж	1,281,817,164.30	1,315,309,173.30
39210	Хуримтлагдсан элэгдэл	-54,059,938.98	-121,902,794.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	345,934,719.30	475,934,719.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-101,631,199.41	-176,923,342.53
393	Биет бус хөрөнгө	137,866,200.00	140,566,200.00
39301	Программ хангамж	139,421,200.00	142,421,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,555,000.00	-1,855,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,337,260,206.13	4,606,630,092.91
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,504,408,829.54	4,816,311,686.74
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,347,205.91	31,304,190.39
413	Өглөг	10,347,205.91	31,304,190.39
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	21,122,881.49
4136	Бусад өглөг	10,347,205.91	10,181,308.90
41361	Байгууллагад төлөх өглөг	4,907,205.91	8,481,308.90
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,440,000.00	1,700,000.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,347,205.91	31,304,190.39
51	Засгийн газрын хувь оролцоо	4,494,061,623.63	4,785,007,496.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	396,403,265.00	396,403,265.00
51101	Өмч: - төрийн	396,403,265.00	396,403,265.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,940,036,904.53	4,230,982,777.25
5121	Өмнөх үеийн үр дүн	3,940,036,904.53	3,940,036,904.53
5122	Тайлант үеийн үр дүн	0.00	290,945,872.72
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	157,621,454.10	157,621,454.10
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,494,061,623.63	4,785,007,496.35
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,504,408,829.54	4,816,311,686.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,230,926,373.00	1,447,249,664.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	144,663,673.00	373,880,714.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	60,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98,000,000.00	311,581,085.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,663,673.00	2,299,629.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,086,262,700.00	1,073,368,950.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,086,262,700.00	1,073,368,950.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	419,580,130.00	487,747,690.47
120	Нийтлэг татварын бус орлого	419,580,130.00	487,747,690.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	419,580,130.00	60,104,460.47
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,802,500.00	2,200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	413,777,630.00	57,904,460.47
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.0	387,800,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.0	39,843,230.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,650,506,503.00	1,934,997,354.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,426,419,375.11	1,560,043,490.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,338,625,212.33	1,463,166,905.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	647,762,089.62	787,908,162.31
210101	Үндсэн цалин	373,892,248.11	787,908,162.31
210102	Нэмэгдэл	205,602,610.09	0.0
210104	Урамшуулал	15,494,158.10	0.0
210105	Гэрээт ажлын хөлс	52,773,073.32	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,233,617.68	95,386,541.93
210201	Тэтгэврийн даатгал	54,841,729.62	66,299,954.30
210202	Тэтгэмжийн даатгал	6,437,105.66	7,752,694.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,231,044.74	4,591,574.22
210204	Ажилгүйдлийн даатгал	2,983,915.95	3,511,052.29
210205	Эрүүл мэндийн даатгал	11,739,821.71	13,231,267.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,730,714.09	107,659,642.90
210301	Гэрэл, цахилгаан	11,849,900.07	15,211,854.86
210302	Түлш, халаалт	70,880,814.02	91,447,788.04
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,068,063.00	16,638,341.00
210401	Бичиг хэрэг	3,045,400.00	1,417,800.00
210402	Тээвэр, шатахуун	44,240,663.00	10,954,941.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,096,600.00	2,620,600.00

210404	Ном, хэвлэл	0.0	305,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0	650,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	685,400.00	690,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,944,500.00	0.0
210604	Урсгал засвар	1,944,500.00	0.0
2107	Томилолт, зочны зардал	16,464,000.00	3,920,000.00
210702	Дотоод албан томилолт	16,464,000.00	3,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,215,532.00	986,360.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	178,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	372,000.00	0.0
210807	Газрын төлбөр	407,032.00	404,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	458,206,695.94	450,667,857.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	234,451,600.00	111,964,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,598,400.00	1,700,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	220,156,695.94	337,003,207.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,794,162.78	96,876,585.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,486,400.00	16,501,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	7,628,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,320,000.00	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,166,400.00	8,873,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	49,307,762.78	80,375,585.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,234,238.78	9,955,585.39
213404	Хөрөнгийн	13,073,524.00	0.0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	70,420,000.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	84,007,991.00
	Дотоод эх үүсвэрээр	0.0	84,007,991.00
223001	Бусад хөрөнгө	0.0	84,007,991.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,426,419,375.11	1,644,051,481.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	224,087,127.89	290,945,872.72
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	224,087,127.89	290,945,872.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,236,728,873.00	1,449,449,664.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,802,500.00	2,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,802,500.00	2,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,802,500.00	2,200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,802,500.00	2,200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,230,926,373.00	1,447,249,664.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	144,663,673.00	373,880,714.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	60,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98,000,000.00	311,581,085.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,663,673.00	2,299,629.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,086,262,700.00	1,073,368,950.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,086,262,700.00	1,073,368,950.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,201,022,273.00	1,146,868,579.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,201,022,273.00	1,146,868,579.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,113,228,110.22	1,049,991,993.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	647,762,089.62	765,818,295.17
210101	Үндсэн цалин	373,892,248.11	439,119,808.63
210102	Нэмэгдэл	205,602,610.09	262,230,260.33
210104	Урамшуулал	15,494,158.10	21,663,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	52,773,073.32	42,805,126.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,286,424.99	96,651,268.00
210201	Тэтгэврийн даатгал	54,894,536.93	65,741,668.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,437,105.66	7,727,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,231,044.74	3,863,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,983,915.95	3,863,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,739,821.71	15,454,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,438,380.61	82,937,959.44
210301	Гэрэл, цахилгаан	11,849,900.07	19,459,759.44
210302	Түлш, халаалт	66,588,480.54	62,478,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,181,373.00	12,420,161.00
210401	Бичиг хэрэг	3,045,400.00	1,343,000.00
210402	Тээвэр, шатахуун	42,117,013.00	7,170,761.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,096,600.00	2,506,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,960.00	650,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	685,400.00	750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,029,500.00	0.0

210604	Урсгал засвар	2,029,500.00	0.0
2107	Томилолт, зочны зардал	17,008,000.00	7,660,000.00
210702	Дотоод албан томилолт	17,008,000.00	7,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,555,532.00	1,008,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	340,000.00	0.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	178,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	372,000.00	
210807	Газрын төлбөр	407,032.00	404,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	237,966,810.00	83,495,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	234,368,410.00	79,295,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,598,400.00	4,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,794,162.78	96,876,585.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,486,400.00	16,501,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	7,628,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,320,000.00	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,166,400.00	8,873,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	49,307,762.78	80,375,585.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,234,238.78	9,955,585.39
213404	Хөрөнгийн	13,073,524.00	0.0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	70,420,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	35,706,600.00	302,581,085.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	35,706,600.00	302,581,085.00
	Дотоод эх үүсвэрээр	35,706,600.00	302,581,085.00
223001	Бусад хөрөнгө		84,007,991.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,706,600.00	218,573,094.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-35,706,600.00	-302,581,085.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	396,403,265.00	157,621,454.10	3,715,949,776.64	4,269,974,495.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,403,265.00	157,621,454.10	3,715,949,776.64	4,269,974,495.74
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	224,087,127.89	224,087,127.89
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,403,265.00	157,621,454.10	3,940,036,904.53	4,494,061,623.63
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	396,403,265.00	157,621,454.10	3,940,036,904.53	4,494,061,623.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,403,265.00	157,621,454.10	3,940,036,904.53	4,494,061,623.63
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	290,945,872.72	290,945,872.72
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,403,265.00	157,621,454.10	4,230,982,777.25	4,785,007,496.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,122,025,500.00	1,063,413,364.61	58,612,135.39	94.78
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,122,025,500.00	1,063,413,364.61	58,612,135.39	94.78
132001	Орон нутгийн төсвөөс	1,122,025,500.00	1,063,413,364.61	58,612,135.39	94.78
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	2,200,000.00	2,800,000.00	44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	2,200,000.00	2,800,000.00	44
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,127,025,500.00	1,065,613,364.61	61,412,135.39	94.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,122,025,500.00	1,065,613,364.61	56,412,135.39	94.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,104,613,100.00	1,049,112,364.61	55,500,735.39	94.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	771,982,900.00	765,303,795.17	6,679,104.83	99.13
210101	Үндсэн цалин	691,303,900.00	438,605,308.63	252,698,591.37	63.45
210102	Нэмэгдэл		262,230,260.33	-262,230,260.33	
210104	Урамшуулал	21,663,100.00	21,663,100.00		100
210105	Гэрээт ажлын хөлс	59,015,900.00	42,805,126.21	16,210,773.79	72.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,592,100.00	96,592,100.00	0.0	100
210201	Тэтгэврийн даатгал	65,682,500.00	65,682,500.00	0.0	100
210202	Тэтгэмжийн даатгал	7,727,200.00	7,727,200.00	0.0	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,863,800.00	3,863,800.00	0.0	100
210204	Ажилгүйдлийн даатгал	3,863,800.00	3,863,800.00	0.0	100
210205	Эрүүл мэндийн даатгал	15,454,800.00	15,454,800.00	0.0	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,938,000.00	82,937,959.44	40.56	100
210301	Гэрэл, цахилгаан	25,373,600.00	19,459,759.44	5,913,840.56	76.69
210302	Түлш, халаалт	55,169,200.00	62,478,200.00	-7,309,000.00	113.3
210303	Цэвэр, бохир ус	2,395,200.00	1,000,000.00	1,395,200.00	41.75
2104	Хангамж, бараа материалын зардал	12,329,400.00	9,814,200.00	2,515,200.00	79.6
210401	Бичиг хэрэг	1,933,100.00	1,343,000.00	590,100.00	69.47
210402	Тээвэр, шатахуун	4,564,800.00	4,564,800.00	0.0	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,233,500.00	2,506,400.00	727,100.00	77.51
210404	Ном, хэвлэл	350,000.00		350,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,350,000.00	650,000.00	700,000.00	48.15
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	898,000.00	750,000.00	148,000.00	83.52
2105	Нормативт зардал	2,100.00	0.0	2,100.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,100.00	0.0	2,100.00	

2107	Томилолт, зочны зардал	8,307,400.00	7,660,000.00	647,400.00	92.21
210702	Дотоод албан томилолт	8,307,400.00	7,660,000.00	647,400.00	92.21
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,357,000.00	4,008,360.00	2,348,640.00	63.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	563,000.00	0.0	563,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	403,200.00	196,800.00	67.2
210803	Даатгалын үйлчилгээ	580,000.00	178,200.00	401,800.00	30.72
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	0.0	500,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	264,000.00	22,000.00	242,000.00	8.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,000,000.00		100
210807	Газрын төлбөр	850,000.00	404,960.00	445,040.00	47.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,104,200.00	82,795,950.00	43,308,250.00	65.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	122,604,200.00	79,295,950.00	43,308,250.00	64.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500,000.00	3,500,000.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,412,400.00	16,501,000.00	911,400.00	94.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,412,400.00	16,501,000.00	911,400.00	94.77
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,920,000.00	7,628,000.00	292,000.00	96.31
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,492,400.00	8,873,000.00	619,400.00	93.47
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,122,025,500.00	1,065,613,364.61	56,412,135.39	94.97
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	
610001	Төсвийн байгууллага	1	1	0	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	29	29	0	
620001	Удирдах ажилтан	3	3	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	13	9	0	
620003	Үйлчлэх ажилтан	3	6	0	
620004	Гэрээт ажилтан	10	4	0	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23	0	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	0	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	0	
650010	Гэрээт ажилтан	1	1	0	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО		373,880,714.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		373,880,714.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		60,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		311,581,085.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,299,629.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		373,880,714.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,879,629.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,879,629.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		514,500.00
210101	Үндсэн цалин		514,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		59,168.00
210201	Тэтгэврийн даатгал		59,168.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,605,961.00
210402	Тээвэр, шатахуун		2,605,961.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		299,581,085.00
	Дотоод эх үүсвэрээр		299,581,085.00
223001	Бусад хөрөнгө		84,007,991.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		215,573,094.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		233,040,714.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сагил сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Сагил сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн "cts-system" программ ашиглан бэлтгэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 311,902.9 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	52.8	350.5	297.7
Бараа материал	167,095.8	209,311.0	42,215.2
Үндсэн хөрөнгө	4,337,260.2	4,606,630.0	269,369.8
Нийт хөрөнгө	4,504,408.8	4,816,311.7	311,902.9
Өр төлбөр	10,347.2	31,304.2	20,957.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,494,061.6	4,785,007.5	290,945.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,504,408.8	4,816,311.7	311,902.9

Мөнгөн хөрөнгийн дансны эхний болон эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 350.5 мянган төгрөг болж 297.7 мянган төгрөгөөр өссөн нь албан хаагчид олгосон цалингийн урьдчилгааг дутуу суутган тооцсонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 209,311.0 мянган төгрөг болж 42,215.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аж ахуйн материал болон нөөцийн өвс, үнэ төлбөргүй хүлээн авсан бусад хангамжийн бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,606,630.9 мянган төгрөг болж 337,830.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Сагил сумын ойн хүрээнд хийгдсэн орон нутгийн хөгжлийн сан болон ард, иргэдийн хандивын эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд нэмэгдсэн 603,573.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,000.0 мянган төгрөгийн программ хангамж нэмэгдсэн, тайлант оны 337,003.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 31,304.2 мянган төгрөг болж 20,957.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн ашгийн татварын өр төлбөр үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,785,007.5 мянган төгрөг болж 290,945.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 993,529.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 993,529.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 239,670.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,233,199.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 111,173.9 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон

орон нутгийн төсвөөс 1,073,369.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Тайлант онд 48,656.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,073,369.0 мянган төгрөг буюу 95.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	618,204.2	607,894.2	10,310.0	99.1%
2	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Баг хорооны ҮА-ны зардал-80106	219,063.0	217,880.2	1,182.8	98.4%
3	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	82,122.0	82,122.0	0.00	100.0%
4	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Нийтлэг үйлчилгээ-80112	73,270.1	73,269.1	1.0	99.9%
5	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	17,412.4	16,501.0	911.4	99.9%
6	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Орон нутгийн нөөц хөрөнгө-81102	20,000.0	13,644.0	6,356.0	68.2%
7	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Мал тооллого- 81507	1,500.0	0	1,500.0	0%
8	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Хур хог хаягдал орчны бохирдол- 82212	1,350.0	650.0	750.0	44.4%
9	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Улсын их баяр наадам- 82801	0.0	0.00	0.0	0%
10	Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх-71413 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх-81701	87,904.0	53,188.0	34,716.0	98.7%
11	Ахмад насны хөгжил хамгаалал-72208 Ахмадын сан-81549	1,200.0	465.0	735.0	38.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	3,000.0	Тайлант онд Санхүүгийн си тэ эс программ 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авч ашиглаж эхэлсэн байна.
2	Унаа, хоолны зардал	0.0	Унаа, хоолны зардал олгоогүй байна.
3	Сургалт, семинар	3,500.0	Албан хаагчид Улаанбаатар хотод Удирдлагын академийн богино хугацааны сургалтад хамрагдсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.

5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	0.0	Зурагтын түүхэн нэвтрүүлэг, нэвтрүүлгийн хөлс
7	Орон тоо	771,982.9	Тайлант онд 23 орон тоо ажиллахаар батлагдсанаас хөдөөгийн багуудын сахиул, олон нийтийн байцаагч, сантехникч нарыг гэрээтээр ажиллуулан 29 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сагил сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 60,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 311,581.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,299.6 мянган төгрөг, нийт 373,880.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сагил сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай 42,082.4 мянган төгрөгийн бараа материал, 3,000.0 мянган төгрөгийн программ хангамж, Сагил сумын 100 жилийн ойн хүрээнд байгууллагын нэмэлт санхүүжилтийн данснаас 199,581.1 мянган төгрөгийн барилга байгууламж, 15,992.0 мянган төгрөгийн зам гүүрний байгууламжийн үндсэн хөрөнгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 2/13 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,426,419.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 14,264.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,644,051.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 16,440.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 13,152.4 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сагил сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг зөрчин бараа үйлчилгээний бусад зардлаас Сагил сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар Хөвсгөл, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хотод нутгийн зөвлөлийн уулзалтад зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 1,499.0 мянган төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дах хэсэгт “Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран батална”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1-д “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно”, 3.6.2-д “Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна”, 3.6.3-д “Төсвийн байгууллага нь картын дансандаа бэлнээр зарцуулах төлбөрийн эх үүсвэрийг шилжүүлэн авах хүсэлтээ харьяа төрийн санд албан бичгээр ирүүлэх бөгөөд бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгасан байна. Төрийн сан албан хүсэлтийг хянан үндэслэлтэй гэж үзвэл шилжүүлгийг баталгаажуулж болно” гэж заасан байна.

Тайлант онд Сагил сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 8,825.0 мянган төгрөгийн гүйлгээг нярвын хувийн дансаар дамжуулан зарцуулсанд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 172, хугацаа хоцроон байршуулсан 9, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сагил сумын Засаг даргын тамгын газрын төсөв, төрийн сангийн мэргэжилтэнд Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны Б/17 дугаар тушаалаар татварын мэргэшсэн зөвлөхийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно” гэж заасныг үндэслэн 10 хувиар тооцож 699.5 мянган төгрөг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь хэсэгт “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс” бүрдэнэ гэж заасантай зөрчилдөж байна. Мөн мэргэшлийн нэмэгдлийн хувь хэмжээг тогтоосон хязгаар байхгүйн учраас байгууллага бүрд харилцан адилгүй олгож байгааг харьяалах дээд шатны байгууллагад санал хүргүүлэхээр болов.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлага өгснийг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 2/34 дүгээр бичгээр биелэлтийг тайлагнан санхүүгийн аудитын fas.audit.mn цахим системд байршуулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд Гулзатын санаачилга төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээгээ дуусгавар болгон Сагил суманд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа 4 Хоршоотой хамтран ажиллах гэрээ байгуулан Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас 36,000.0 мянган төгрөгийн зарцуулалт гарсныг Сагил сумын Засаг даргын тамгын газрын Байгаль орчны тасаг хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Сагил сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоонд байхгүй селесерь, олон нийтийн цагдаа, хөдөөгийн багуудын сахиулыг ажиллуулж төсвөөс 46,954.3 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,324.0 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 8,499.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 8,825.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

5.2 Албан шаардлага-1

Сагил сумын Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардлаас Сагил сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар Хөвсгөл, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хотод нутгийн зөвлөлийн уулзалтад зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 1,499.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өглөө.

Албан шаардлага-2

Сагил сумын Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардал, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас Сагил сумын Засаг даргын 2025 оны А/04 дүгээр захирамжаар 2,000.0 мянга, Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/05 дугаар тушаалаар 5,000.0 мянга нийт 7,000.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Зардлын данстай холбоотой

Тайлант онд Сагил сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 8,825.0 мянган төгрөгийн гүйлгээг нярвын хувийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт “Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран батална”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1-д “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно”, 3.6.2-д “Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас

зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна”, 3.6.3-д “Төсвийн байгууллага нь картын дансандаа бэлнээр зарцуулах төлбөрийн эх үүсвэрийг шилжүүлэн авах хүсэлтээ харьяа төрийн санд албан бичгээр ирүүлэх бөгөөд бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгасан байна. Төрийн сан албан хүсэлтийг хянан үндэслэлтэй гэж үзвэл шилжүүлгийг баталгаажуулж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид байгууллагын нярвын хувийн дансаар бэлэн мөнгө гарган зарцуулахгүй байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сагил сумын Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардлаас Сагил сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар Хөвсгөл, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хотод нутгийн зөвлөлийн уулзалтад зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 1,499.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	1,499.0			1	1,499.0						

Сагил сумын Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардал, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас Сагил сумын Засаг даргын 2025 оны А/04 дүгээр захирамжаар 2,000.0 мянга, Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/05 дугаар тушаалаар 5,000.0 мянга нийт 7,000.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.	1	7,000.0			1	7,000.0				
Дүн	2	8,499.0			2	8,499.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сагил сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 8,825.0 мянган төгрөгийн гүйлгээг байгууллагын картын данс байхгүйн улмаас нярвын дансаар дамжуулан зарцуулсан байна.	1	8,825.0					1	8,825.0
Дүн	1	8,825.0					1	8,825.0
Нийт дүн	1	8,825.0					1	8,825.0

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.АМАРМЭНД/

2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/20/А2070413
УВА-2026/029/НА-СТА-ТМЗ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сагил сумын Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардлаас Сагил сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар Хөвсгөл, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хотод нутгийн зөвлөлийн уулзалтад зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 1,499.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.6 дахь заалтад “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр хуулиар хориглосон зардал буюу бэлэг худалдан авахыг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сагил сумын Засаг даргын тамгын газрын дарга Д.Сумъяа, нягтлан бодогч З.Бат-Оргил нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.АМАРМЭНД

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ





УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 02/21/А 2020 413
УВА-2026/029/НА-СТА-ТШЗ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сагил сумын Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардал, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас Сагил сумын Засаг даргын 2025 оны А/04 дүгээр захирамжаар 2,000.0 мянга, Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/05 дугаар тушаалаар 5,000.0 мянга нийт 7,000.0 мянган төгрөгийг бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйцээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр хуулиар хориглосон зардал буюу бэлэг худалдан авахыг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сагил сумын Засаг даргын тамгын газрын дарга Д.Сумъяа, нягтлан бодогч З.Бат-Оргил нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР



Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ